Төсөл

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2023 оны ... дугаар
сарын ...-ний өдөр

Улаанбаатар
хот

ЭРҮҮГИЙН ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Эрүүгийн хуульд дор дурдсан агуулгатай дараах зүйл, хэсэг нэмсүгэй:

1/27.9 дүгээр зүйл.

"27.9 дугаар зүйл.Агаарын хөлгийн нислэг, аюулгүй байдалд халдах

1.Агаарын хөлгийн нислэгт аюул учруулж болохуйц худал мэдээллийг санаатайгаар өгсөн, нислэг үйлдэж байгаа агаарын хөлгийн бүхээгт яваа хүний эсрэг хүч хэрэглэж, агаарын хөлгийн аюулгүй байдалд аюул учруулсан, ашиглалтад байгаа агаарын хөлөг, түүний эд ангийг устгасан, гэмтээсэн, ашиглах боломжгүй болгосон, агаарын хөлөгт нислэг үйлдэх боломжгүй болохуйц хохирол учруулахаар гэмтээх чадалтай төхөөрөмж, бодисыг байрлуулсан, эдгээр гэмт хэргийг үйлдэхээр заналхийлсэн бол хоёр жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

2.Агаарын хөлгийн бүхээгт хүний амь нас хохироох, эрүүл мэнд, өмч хөрөнгөд хохирол учруулахад чиглэсэн тэсрэх, цацраг идэвхт материал, биологийн, химийн, цөмийн зэвсэг, тэдгээрийг боловсруулах, ашиглах, үйлдвэрлэх, зохион бүтээхэд зориулсан программ хангамж, технологи, тусгай материал, тоног төхөөрөмжийг тээвэрлэсэн, тээвэрлэхэд хүргэсэн бол хоёр жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

3.Ашиглалтад байгаа агаарын хөлгийг хүний амь нас хохироох, эрүүл мэндэд ноцтой хохирол учруулах, өмч хөрөнгө, хүрээлэн буй орчинд их хэмжээний хохирол учруулахад ашигласан, учруулж болох тийм аргаар биологийн, химийн, цөмийн аливаа зэвсэг, тэсрэх цацраг идэвхт, тэдгээртэй адилтгах зүйлийг агаарын хөлгийн бүхээгт ашигласан, агаарын хөлгөөс гаргасан, хаясан бол таван жилээс арван хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

Тайлбар: Энэ зүйлд заасан "ашиглалтад байгаа агаарын хөлөг" гэж газрын бие бүрэлдэхүүн буюу багаас тодорхой нислэг хийхээр агаарын хөлгийг нислэгийн өмнө бэлтгэж эхэлсэн үеэс уг агаарын хөлөг бууснаас хойш 24 цаг өнгөрөх хүртэлх хугацааг хэлнэ."

2/27.10 дугаар зүйл.

"27.10 дугаар зүйл.Нисэх буудлын аюулгүй байдалд аюул учруулах

1.Нисэх буудал, нисэх буудлын байгууламжид байрласан, ашиглаагүй агаарын хөлгийг устгасан, ноцтой гэмтэл учруулсан, нисэх буудлын ажиллагааны хэвийн горимыг алдагдуулсан нь нисэх буудлын аюулгүй байдалд заналхийлсэн бол хоёр жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ."

2 дугаар зүйл.Эрүүгийн хуулийн 27.9, 27.10, 27.11 дүгээр зүйлийн дугаарлалтыг 27.11, 27.12, 27.13 гэж тус тус өөрчилсүгэй.

3 дугаар зүйл.Эрүүгийн хуулийн 27.1 дүгээр зүйл болон тус зүйлийн 1, 2 дахь хэсгийн "агаарын хөлгийн" гэснийг тус тус хассугай.

ГАРЫН ҮСЭГ